

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



МОНГОЛ УЛС: 2020-2024 ОНД АЖИЛЛАХ УЛСЫН ИХ ХУРАЛД САНАЛ БОЛГОХ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ



Эмнести Интернэшнл нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 7 сая гаруй гишүүн, дэмжигч, хүний эрх хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг.

Монгол Улсын Их Хуралд шинээр сонгогдсон гишүүд та бүхнийг Монгол Улсын хүний эрхийн үзүүлэлтийг сайжруулах, хүний эрхийг хүндэтгэн хамгаалдаг болохоо нотлон харуулахыг Монголын Эмнести Интернэшнл уриалж байна.

Өмнөх Засгийн газар Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаар НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө¹ баталсныг Монголын Эмнести Интернэшнл онцлон тэмдэглэж байна.

Монгол Улс бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан Эрүүгийн хууль(шинэчилсэн найруулга), эрүүдэн шүүхийг, эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг шүүх ажиллагаанд нотлох баримт болгож ашиглахыг илт хориглосон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) баталж, хэрэгжүүлж байгаа нь амьд явах, эрүү шүүлт, зүй бус харьцаанаас ангид байх эрхийн биелэлтийг хангах бодит алхам боллоо.

Гэхдээ Монгол Улсын хувьд олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд хууль, тогтоомжоо нийцүүлэн, сайжруулах шаардлагатай олон ажил хүлээгдэж байна. Монгол Улс өнгөрсөн хугацаанд өмнөх хүний эрхийн амжилтаасаа ухарсан үйлдлийг гаргалаа. 2019 онд Монгол Улсын Их Хурлаас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар шүүхийн хараат бус байдлыг дордуулж байгаад Монголын Эмнести Интернэшнл харамсаж байна. Түүнчлэн Засгийн газраас эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааны хохирогч болсон хүмүүсийн хөндөгдсөн эрхээ бүрэн нөхөн сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлэх механизмыг байгуулсангүй.

Хот дахин төлөвлөлтийн төсөл нийслэл Улаанбаатар хотод хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн ч холбогдох хууль, зохих бодлого, журмыг гаргахгүй хугацаа алдсаны уршгаар дахин төлөвлөлтөд хамрагдаж буй хүмүүсийн эрх ялангуяа шаардлагад нийцсэн орон байртай байх эрх зөрчигдсөн хэвээр байна.

Хүний эрх хамгаалагчид эрх баригчдын зүгээс явуулж буй элдэв хязгаарлалт, ялгаварлан гадуурхалт, айлган сүрдүүлэлтэд өртсөөр байна. Тэд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй явуулахад нь нэн шаардлагатай байгаа арга механизм, сүлжээ, мэдээллээр хангагдахгүй байна.

Тиймээс Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг Монгол Улсад хүний эрхийг хүндэтгэн, хамгаалах ажлынхаа нэг хэсэг болгож хүн бүр эрүү шүүлт, айдас, хавчлагаас ангид байх эрх, шүүхийн хараат бус, бие даасан байдал, шударгаар шүүлгэх эрх, хохирогчдын хамгаалалт, бодлого, хөтөлбөрүүдийн хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн байдал, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл хүлээн авах эрхийг үл хязгаарлахаа баталгаажуулахыг уриалж байна.

¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө, Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралт

I. ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ

2015 онд НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлгээр Монгол Улсын нөхцөл байдлыг хэлэлцсэнээс хойш Монгол Улс 2015 оны 12 дугаар сард бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) батлах зэргээр хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулах хэд хэдэн санаачилгыг эхлүүлсэн.

Гэвч Монгол Улсын Их Хурлаас 2019 онд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргаас бүрдсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд шүүхийн ерөнхий шүүгчид, ерөнхий прокурор, түүний орлогчид, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нарыг ажлаас чөлөөлөх зөвлөмж гаргах эрхийг олгосон. НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын Тусгай илтгэгч эдгээр өөрчлөлтийн талаар “эрх мэдлийн хуваарилалтыг эрс эвдэж, шүүхийн хараат бус байдлыг ноцтойгоор бууруулж, харилцан хяналт тавих зарчмыг алдагдуулсан хэрэг бөгөөд авилгал, ял завшихтай тэмцэх шүүхийн чадавхийг хязгаарлана” хэмээн санаа зовиож буйгаа илэрхийлсэн.

Зөвлөмж:

1. Бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан байдлаа хадгалах
2. Шүүхийн хараат бус байдал, прокурорын байгууллагын бие даасан байдлыг сулруулсан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хуульд оруулсан 2019 оны 3-р сарын 27-ны өдрийн нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгох,

II. ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ, ШИЙТГЭХ, ЯЛ ЗАВШИХ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ

2017 оны 7 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад эрүүдэн шүүхийг, эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг шүүх ажиллагаанд нотлох баримт болгож ашиглахыг илт хориглосон нь эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг хангах бодит алхам болсон.

Гэвч мэдүүлэг авахын тулд эрүүдэн шүүж, зүй бус харьцах тохиолдол гарсаар байгаа ба хорих газарт хүмүүсийг эрүүдэн шүүсэн, зүй бус харьцсан хэргийг мэдээлэхгүй байгаа нь ял завшуулах явдлыг улам нэмэгдүүлж байна. Сүүлийн жилүүдэд тагнуулын газрын ажилтан, цэргийн бие бүрэлдэхүүн, цагдаа гэх мэт хууль сахиулах байгууллагын ажилтнуудтай холбоотой эрүүдэн шүүж, зүй бус харьцсан гэх гомдлууд гарсан ч эдгээр зөрчлийг мөрдөн шалгах ажиллагаа, хууль сахиулагчдыг шүүх ажиллагааны үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлээгүй байна. Мөн эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх тухайд хууль сахиулах байгууллагын ажилтнуудад

сургалт явуулах зарим арга хэмжээ авч хэрэгжүүлснийг эс тооцвол эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, түр орогнох байрны үйлчилгээ үзүүлэгч, асрамжийн газрын ажилтан, цэргийн бие бүрэлдэхүүн зэрэг бусад төрийн албан хаагч нарт сургалт хийгдэхгүй байна.

Зөвлөмж:

1. Хууль сахиулагчидтай холбоотой болон бусад эрүүдэн шүүж, зүй бус харьцсан тухай бүх мэдүүлэг, өргөдөл гомдлыг хараат бус, бие даасан байгууллагаар яаралтай, үр дүнтэй, шударгаар мөрдөн шалгуулж, эрүүдэн шүүгчдэд хариуцлага хүлээлгэдэг байхыг баталгаажуулах;
2. Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааны хохирогчдын олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн, шаардлага хангасан нөхөн олговор авах, нөхөн сэргээлгэх эрхийг нь яаралтай баталгаажуулах;
3. Бүх насаар хорих болон урт хугацааны ялтай этгээдийн бие махбод, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарсан бодлого гаргаж хэрэгжүүлэх, ийм хүмүүстэй ажилладаг хорих байгууллагын холбогдох ажилтнуудыг зохих сургалтанд хамруулах

III. ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Хотын хүн амын хэт бөөгнөрөл, агаар, хөрсний бохирдол, инженерийн дэд бүтцийн дутмаг байдал, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих зэрэг тулгамдаж буй олон хүчин зүйлийн нөлөөгөөр Улаанбаатар хотыг дахин төлөвлөхдөө төрөөс бодлогын түвшинд, нэгдмэл зохион байгуулалттайгаар, эрх зүйн бүрэн хамгааллын доор хэрэгжүүлээгүйгээс үүдэн олон сөрөг үр дагавар үүсэж байна.

Улаанбаатар хотод дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн ч хууль, эрх зүйн орчны хийдэл, хэрэгжилтийн хангалтгүй байдал, холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоогүй, хариуцлагагүй байдал, дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлж буй барилгын компаниудын зүгээс учруулж буй эрсдэлээс шалтгаалан дахин төлөвлөлтөд хамрагдсан иргэдийн эрх зөрчигдсөөр байна.

Хот байгуулалтын тухай болон Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, уг хуулийг даган гарсан журмууд нь хүний эрхийн талаарх олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй нийцэхгүй байна. Гуравдагч этгээд буюу төсөл хэрэгжүүлэгч барилгын компанийн зүгээс иргэдийн орон байрны халдашгүй байдалд шууд халдахаас хамгаалсан эрх зүйн орчин, бодлогын шийдэл дутмаг байна.

Нийслэлийн удирдлагуудын зүгээс Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор 2017 онд орон нутгаас нийслэлд шилжин ирэх хөдөлгөөнийг тодорхой хугацаанд хориглосон шийдвэр гаргасан нь бусад хууль тогтоомжтойгоо зөрчилдөж байгаа бөгөөд бодит байдал дээр анх тавьсан зорилгодоо хүрч шилжилт хөдөлгөөнийг зогсоож чадаагүй. Үүний улмаас хотын захын гэр хороололд албан бусаар суурьшсан хүмүүс хаягийн шилжилт хийлгэх боломжгүй болж, нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй эрх нь зөрчигдсөөр байна. Хот дахин төлөвлөлтийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэд гомдол гаргах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, зөрчигдсэн эрхээ хамгаалуулахад хүндрэлтэй байна.

Зөвлөмж:

1. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай болон дахин төлөвлөлттэй холбоотой хууль тогтоомжид олон улсын хүний эрхийн хуулиар хамгаалагдсан орон байраар хангагдах эрхийн хамгаалалт (газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, албадан нүүлгэлтийг хориглох гэх мэт)-ыг цогцоор нь тусгаж, шинэчлэн батлах. Үүнд: хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр гарах журмууд мөн адил хамаарна;
2. Дахин төлөвлөлттэй холбоотой хууль тогтоомжийн уялдааг сайжруулж, хот дахин төлөвлөх, процесс процедурыг хянах, хариуцлага тооцох механизмыг бий болгож хуульчлах,
3. Дахин төлөвлөлтийн хүрээнд иргэдийг албадан нүүлгэх, хүч хэрэглэх байдлыг хориглож, зайлшгүй тохиолдолд нүүлгэхийн өмнө заавал дагаж мөрдөх хамгаалалтын арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
4. Гуравдагч этгээд буюу аливаа хувийн хэвшлийн зүгээс дахин төлөвлөлтөд хамрагдаж, газар чөлөөлөлтөд өртөж буй хүмүүсийн эрхийг хүндэтгэх явдлыг төр баталгаажуулах, тухайн харилцаанд оролцогчдын эрх үүргийг тодорхой болгож, хэрэгжилтийг хангуулах;
5. Хуулиас давсан журмаар иргэдийн орон байраар хангагдах эрх ноцтой зөрчигдөж, орон гэргүй болсон сөрөг үр дагаврыг арилгаж, тухайн иргэдийг хохиролгүй болгох, хөндөгдсөн эрхийг сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

IV. ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ АСУУДЛААРХ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ ЗОГСООХ

Эрх баригчид цэвэр ус, газар, бэлчээр ашиглах, эзэмших болон уламжлалт өв соёл, амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас малчдыг хамгаалж чадахгүй байна. Иргэд амьдардаг суурьшлын бүсэд уул уурхайн компани хортой хог хаягдал хаясны улмаар иргэд хордсон тухай

болон хортой хог, бохирдлын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгуулахгүй хэмээн уул уурхайн компаниуд малчдыг айлган сүрдүүлж буй талаарх гомдлуудыг Эмнести Интернэшнл хүлээж аваад байна.

Зөвлөмж:

1. Компаниудад хүний эрхийг хүндэтгэн, байгаль орчныг хамгаалах, хүний эрхийн талаарх хуульд заасан үүрэг хариуцлагаа биелүүлэхийг шаардсан хэм хэмжээ бий болгож, чанд мөрдүүлэх;
2. Компанийн явуулж буй үйл ажиллагаа нь хүний эрх болон байгаль орчинд ямар нөлөө үзүүлж болох тухай мэдээллийг заавал нийтэлдэг болох, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг олон нийтэд дэлгэдэг тогтолцоотой болгох
3. Хорт бодисын хадгалалт, хамгаалалт, устгалд хяналт тавих тогтолцоог цогцоор нь сайжруулж, хорт бодисын улмаас эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохирсон иргэдэд хохирлоо үр дүнтэй нөхөн төлүүлэх эрх зүйн орчин бий болгох.

V. ХАЛДЛАГА, АЙЛГАН СҮРДҮҮЛЭЛТ, ЗАНАЛХИЙЛЛЭЭС ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ

Монголд байгаа хүний эрх хамгаалагчид халдлагад өртөж байна. Засгийн газар хүний эрх хамгаалагчдыг төрийн бус оролцогчдын зүгээс ирж буй халдлага, заналхийллээс хамгаалж чадсангүй.

Орон байртай байх эрхийг хамгаалагч, сэтгүүлч, хүрээлэн буй орчны асуудлаарх идэвхтнүүд рүү дугаараа нууцалсан утаснаас залган цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх зэрэг үйл ажиллагаагаа зогсоохыг шаардаж, дарамталжээ. Мөн хууль сахиулагчид, төрийн албан хаагчдын зүгээс сэтгүүлчид, хүрээлэн буй орчны асуудлаар ажиллаж буй идэвхтнүүдийг айлган сүрдүүлж, заналхийлсэн тухай мэдээлэл байна.

Халдлага үйлдэгчдийг мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэх механизм, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах цогц хамгаалалт дутагдаж байгаа нь тэднийг дарамталсан, айлган сүрдүүлсэн хэрэгт ял завшуулахад хүргэж байна.

Зөвлөмж:

1. Хүний эрх хамгаалагчийг таниулсан, хамгаалсан хууль баталж, хүний эрх хамгаалагчид хүний эрхийг хөхиүлэн дэмжиж, хамгаалах үйл ажиллагаагаа явуулж чадаж байгаа эсэхийг баталгаажуулах;
2. Хүний эрх хамгаалагчийн эсрэг үйлдэгдсэн зөрчил, хүчирхийллийг яаралтай, хараат бусаар бүрэн мөрдөн шалгах, гэм буруутай

этгээдийг шударгаар шүүх, хохирлыг барагдуулах, хохирогчдын эрхийг үр дүнтэйгээр нөхөн сэргээх зэргээр хүний эрх хамгаалагчдын эсрэг гарч буй айлган сүрдүүлэлт, дарамт шахалт, халдлага, заналхийллийг зогсоох үр дүнтэй арга хэмжээ авах;

3. Тайван замаар жагсаал цуглаан хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлснийх нь төлөө эрүүгийн хэрэгт татах, бусад шүүхийн болон захиргааны арга хэмжээ авахгүй байх.

VI. ЧАНАРТАЙ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ

НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс 2011 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталсан Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын Тунхаглалаар хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг дэмжих зорилгоор *Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөр болон Тунхаглалыг* баталсан. Уг хөтөлбөр нь багш, сурган хүмүүжүүлэгч, бодлого боловсруулагчдад үндэсний бодлого, тэргүүлэх зорилтуудаа олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэн дахин нягтлах боломжийг олгож байгаа юм.

Зөвлөмж:

1. Монгол Улс хүн бүрийн эрхийг хамгаалах, хүндэтгэх соёлыг төлөвшүүлэх зорилгоор дээрх Тунхаглалыг хүмүүст хүргэх, түүнийг нийтээр хүндэтгэн, ухаж ойлгох явдлыг сурталчлах үйлст хүчин чармайлтаа нэмэгдүүлэхээ баталгаажуулах;